



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/В/14

Чингис хот

Голомтын халдваргүйтгэлийн
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 34.2.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.12 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт болон малаас хүнд халдварладаг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор боом, галзуу өвчний голомтуудыг халдваргүйтгэх ажлыг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Халдваргүйтгэлийн ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумдын Мал эмнэлгийн тасаг, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал, амьтнаас хүнд халдварладаг зооноз өвчний голомтуудыг халдваргүйтгэх ажилд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн "Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх сан"-аас гаргах зардлыг нэгдүгээр, сумдын Засаг даргын тамгын газраас гаргах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, зарцуулсугай.

4. Голомтын халдваргүйтгэлийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн "Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх сан"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

5. Мэргэжил арга зүйн заавар, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, шаардагдах эмийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, ажлын үр дүн, нэгдсэн тайлан мэдээг 10 дугаар сарын 01-ний өдөрт багтаан аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
 04 дугаар сарын 20 өдрийн АЗД
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**2020 ОНД БООМ, ГАЛЗУУ ӨВЧНИЙ ГОЛОМТУУДЫГ
 ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Сумын нэр	Халдваргүйтгэх голомтын тоо			Сумаас голомт	Голомт халдваргүйтгэхэд зарцуулах шатахуун						НИЙТ ДҮН	
	Боом	Галзуу	Бүгд		Автомашинд дизель түлш / литр /			Мотор ажиллуулахад А-80 / литр /				
					Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд үнэ	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд үнэ		
1	Галшар		4	4	82	2320	16	37120	1580	4	6320	43440
2	Баянхутаг	9	2	11	305	2270	61	138470	1510	11	16610	155080
3	Дархан		2	2	105	2370	21	49770	1630	2	3260	53030
4	Баянмөнх		1	1	30	2370	6	14220	1630	1	1630	15850
5	Дэлгэрхаан	17		17	277	2320	55	127600	1590	17	27030	154630
6	Жаргалтхаан	6	1	7	368	2250	74	166500	1490	7	10430	176930
7	Өмнөдэлгэр	17	3	20	380	2270	76	172520	1470	20	29400	201920
8	Биндэр	15		15	377	2320	75	174000	1570	15	23550	197550
9	Баян-Адарга	3		3	204	2120	41	86920	1410	3	4230	91150
10	Норовлин	5		5	250	2380	50	119000	1610	5	8050	127050
11	Батноров		5	5	202	2310	40	92400	1570	5	7850	100250
12	Баян-Овоо	2	1	3	122	2130	24	51120	1480	3	4440	55560
13	Мөрөн	2	10	12	141	2260	28	63280	1500	12	18000	81280
14	Хэрлэн		11	11	300	2150	60	129000	1510	11	16610	145610
Дүн		76	40	116	3143		629	1421920		116	177410	1599330

Аймгийн Засаг даргын 2020 оны
 04 дугаар сарын 20 өдрийн 424
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



2020 ОНД ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТУУДЫГ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХЭД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРААС ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Сумын нэр	Аймгаас сум, сумаас сум хооронд явах км	Ариутгах голомтын тоо			Сумаас гарах зардал			МЭГЗраас гарах зардал		Нийт зардлын дүн
			Боом	Галзуу	Бүгд	Шаардагдах шатахуун /А-92 бензин /			Томилолт /зам хоног 12000, буудал 14500 /		
						Нэг бүрийн үнэ	Хэмжээ /литр/	Бүгд үнэ	Ажиллах хоног	/Жолооч, эмч-2 хүн /	
1	Баянхутаг	22	9	2	11	1550	4	6200			6200
2	Галшар	125		4	4	1610	25	40250	1	53000	93250
3	Дархан	100		2	2	1660	20	33200			38400
4	Баянмөнх	40		1	1	1660	8	13280			15280
5	Дэлгэрхаан	45	17		17	1620	9	14580	2	106000	120580
6	Жаргалтхаан	70	6	1	7	1530	14	21420			21420
7	Өмнөдэлгэр	135	17	3	20	1520	27	41040	2	106000	147040
8	Биндэр	130	15		15	1610	26	41860	2	106000	147860
9	Баян-Адарга	45	3		3	1510	9	13590			13590
10	Норовлин	80	5		5	1640	16	26240	1	53000	79240
11	Батноров	100		5	5	1610	20	32200			32200
12	Баян-Овоо	52	2	1	3	1580	10	15800	1	53000	68800
13	Хэрлэн	165		11	11	1550	33	51150	1	53000	104150
14	Мөрөн	30	2	10	12	1540	6	9240			9240
15	Чингис	30				1550	6	9300			11100
Дүн		1169	76	40	116		234	369350	10	530000	908350